



**“ЭРДЭНЭТИЙН ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2026 оны 04 сар 01 өдөр

Дугаар

81/45

Эрдэнэт хот

Авлигын эсрэг үйл
ажиллагааны төлөвлөгөөг батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4.1, 84.4.3 дахь заалтууд, Авлигын эсрэг хуулийн 5, 6 дугаар зүйлд заасан үүргийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ НЬ:

1. Эрдэнэтийн дулааны цахилгаан станц төрийн өмчит хувьцаат компанийн 2026 оны “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-г хавсралтаар баталсугай.
2. Төлөвлөгөөний хэрэгжилтийг анхаарч, биелэлтэд хяналт тавьж, хугацаанд нь тайлагнаж ажиллахыг хүний нөөцийн ажилтан (Т.Баялаг)-д даалгасугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтсийн дарга (Б.Жигмэддорж)-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.БАТ-ЭРДЭНЭ



“ЭДЦС ТӨХК”-ийн гүйцэтгэх захирлын 2026 оны дугаар сарын 01 өдрийн дугаар тушаалын хавсралт

ЭРДЭНЭТНИЙ ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦЫН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ 2026 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хариуцах эзэн	Хугацаа
Зорилт 1. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх						
1.	1.1. Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг а/байгууллагын албан ёсны цахим хуудас; б/сошиал сувгууд; в/дотоод сүлжээ; д/мэдээлэл сурталчилгаа самбар, лед дэлгэц, е/бусад (салбар байгууллагууд) хэлбэрээр сурталчилж, олон нийтэд хүргэх;	Байршуулсан тоо, түгээсэн суваг, давтамж, хандалтын тоо.	-Авлигатай тэмцэх мэдээ, мэдээллийг тогтмол шинэчлэн, тогтвортой байршуулж тайланд нотломжийг хавсаргасан байна. -Цахим хуудас, сошиал сувгуудад мэдээллийг оруулсан байна.	ЭБАТ	Жилдээ	
2.	1.2 Өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан авлигын эрсдэлээс ангид байх, ёс зүй, залуусыг авлигын эсрэг оролцоотой, зөв, шударга байдлыг уриалсан гарын авлага хийх, сурталчилах	Нотломжийг хавсаргах	Авлигын эрсдэлээс ангид байх, ёс зүй, залуусыг авлигын эсрэг оролцоотой, зөв, шударга байдлыг гарын авлага хийж тараах	ЭБАТ, ЗУХ ИА	Жилдээ	
3.	1.3. Өөрийн байгууллагын эрх хэмжээ, үйл ажиллагаатай холбогдуулан ажилтнуудад шүгэл үлээхийг уриалсан мэдээлэл өгөх суваг, хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын сурталчлах;	Хэвлүүлсэн зурагт хуудас, хэвлэмэл сэтгүүл, материалын тоо	Авлигын мэдээлэх 1-110 дугаарыг сурталчилсан байна.	ИА, ЭБАТ	Жилдээ	
Зорилт 2. Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийн бууруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх						
4.	2.1. Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд ажилтнуудын оролцоог нэмэгдүүлэх;	- Хамрагдсан тоо	Бүх нэгжүүдийг хамрах	ЭБАТ, Хуулийн	Жилдээ	

				зөвлөх, ХНА-нууд	
5.	2.2. Байгууллагын цахим хуудсанд дүн шинжилгээ хийж, мэдээллийг ил тод байдлыг хангаж ажиллах;	- Засгийн газрын 2022 оны 353 дугаар тогтоолыг баримталсан байх; - Байршуулбал зохих мэдээллийн тоо	Мэдээлбэл зохих бүх мэдээллийг байршуулж ажиллана.	ЭБАТ, ИА	Жилдээ
6.	2.3. Байгууллагуудын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлж хэвших;	Шинэ томилогдсон албан хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ёс зүйн сургалтад бүрэн хамруулсан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх. -Ирүүлсэн гомдолд дүн шинжилгээ хийсэн байх	Ирүүлсэн гомдолд дүн шинжилгээ хийсэн байх	ЭБАТ, Захирлын туслал, архивч	Жилдээ
7	2.4 Олон нийтэд нээлттэй, ил тод болгохоор заасан мэдээллийг тухай бүр цахим системд нээлттэй байршуулж, олон нийтэд ил тод мэдээлнэ.	Олон нийтэд нээлттэй, ил тод болгохоор заасан мэдээллийг тухай бүр цахим системд нээлттэй байршуулах	Олон нийтэд нээлттэй байршуулсан мэдээлэл	ЭБАТ, Шилэн данс хариуцсан ажилтнууд	Хуулийн хугацаанд
Зорилт 3. Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах					
8	3.1. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр ЭБАТ-дад сургалтыг зохион байгуулах;	Бүрэн хамрагдсан эсэх талаар баримт тоо, мэдээлэл	ЭБАТ-ууд албан хаагчдын дунд авлигаас ангид байхад чиглэсэн нөлөөллийг бий болгосон байх	ЭБАТ	Хагас, бүтэн жилээр
9	3.2 Эрчим хүч салбарын алба хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийг арилгахад чиглэсэн сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах;		Сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан байх;	ЭБАТ ХНА-ууд	Жилдээ
10	3.3. Байгууллагын дотоод хяналтын механизмыг сайжруулж, албан хаагчдыг авлига, ашиг сонирхлоос ангид байхад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх;		Байгууллагын алба хаагчид авлигын гэмт хэрэгт холбогдоогүй байх;	Нууцийн ажилтан, ЭБАТ	Жилдээ